НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛД
САЙН ДУРААР ДААТГУУЛЖ
ИРЭЭДҮЙГЭЭ ЭРСДЛЭЭС
ХАМГААЛЪЯ

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ХЭРХЭН ДААТГУУЛАХ ВЭ?

1. Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас доор дурдсан бусад иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах боломжтой:

    - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
    - Малчин
    - Газар тариалан эрхлэгч
    - Бичил уурхай эрхлэгч
    - Чөлөөт уран бүтээлч
    - Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн
    - Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэн
    - Оюутан суралцагч
    - Бусад иргэн

2. Хөдөлмөрийн гэрээ бүхий доор дурдсан иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулна:
   (Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсэг)

    - Туслах малчин
    - Гэрийн үйлчилгээний ажилтан
    - Бусад ажилтан

ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

Сайн дураар даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээр тохирсон хугацаанд өөрийн мэдүүлсэн сарын хөдөлмөрийн хөлс, орлогоосоо доорх хувь хэмжээгээр шимтгэлээ төлнө:

Даатгалын төрөл	Шимтгэлийн хувь хэмжээ
Тэтгэврийн даатгал	11.5%
Тэтгэмжийн даатгал	1.0%
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	1.0%
Нийт	**13.5%**

* *Сайн дурын даатгуулагчийн шимтгэл тооцох сарын орлогын хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс ихгүй байна.*

Тухайлбал, таны мэдүүлсэн сарын орлого:

- 420 000 төгрөг бол та сард **56 700** (420 000 x 13.5%) төгрөгийн шимтгэл төлнө.
- 800 000 төгрөг бол та сард **108 000** (800 000 x 13.5%) төгрөгийн шимтгэл төлнө.
- 4 200 000 төгрөг бол та сард **567 000** (4 200 000 x 13.5%) төгрөгийн шимтгэл төлнө.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Та сайн дураар даатгуулснаар нийгмийн даатгалын дараах үйлчилгээг авах эрхтэй:

Тэтгэврийн даатгалын сангаас:

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж

ҮОМШӨ-ий даатгалын сангаас:

- Тахир дутуугийн тэтгэмж
- Тэжээгчээ алдсаны тэтгэмж
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр
- Тэтгэврийн даатгалын шимтгэл
- Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилалд ирэх, очих унааны зардал
- Мэргэжлээс шалтгаалсан өвчний өвчний сувиллын тусламж, үйлчилгээний зардал

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, СУНГАХ

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг Нийгмийн даатгалын хэлтэст хандах эсвэл **Цахим** хэлбэрээр “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн, www.daatguulagch.ndaatgal.mn даатгуулагчид зориулсан вэбийн тусламжтайгаар байгуулах, сунгах боломжтой.

Та цахимаар даатгуулах үйлчилгээг авснаар:



- Шинээр гэрээ байгуулах
- Гэрээгээ сунгах
- Шилжилт хөдөлгөөнөө бүртгүүлэх
- Шимтгэлийн төлбөрөө төлөх
- Төлөгдсөн шимтгэлээ хянах
- Авсан тэтгэвэр, тэтгэмжийн талаар мэдээлэл авах
- Мэдэгдэл хүлээн авах боломжтой.

Та гэрээгээ байгуулахдаа гэрээний хугацаа; шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого; шимтгэл төлөх нийгмийн даатгалын байгууллага; ажил эрхлэлтийн байдал зэрэг гэрээний нөхцөлөө өөрөө тодорхойлно. Таны тодорхойлсон орлогод үндэслэн шимтгэлийн төлбөр автоматаар бодогдох ба өөрийн харилцагч банкны аппликейшн рүү шууд холбогдож шимтгэлийн төлбөрөө төлнө.

GET IT ON Google Play

Download on the App Store